



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/867

Ховд

Өр барагдуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, 43 дугаар зүйлийн 43.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Аймгийн 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулж батлах тухай” 04/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгууллагуудын халаалтын хугацаанд орсон өөрчлөлттэй холбоотойгоор үүссэн халаалтын өр барагдуулахад 21 350 934.33 төгрөг /хорин нэгэн сая гурван зуун тавин мянга есөн зуун гучин дөрвөн төгрөг гучин гурван мөнгө/-ийг хавсралтаар баталж зарцуулсугай.


2. Хавсралтад заасан өр барагдуулах 21 350 934 төгрөг 33 мөнгийг татан төвлөрүүлэлтийн данснаас хавсралтад заасан байгууллагуудын халаалтын өрийг барагдуулахаар санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны  
12 дугаар сарын 27-ны өдрийн  
А/867 дугаар захирамжийн хавсралт



БАЙГУУЛЛАГУУДЫН ХАЛААЛТЫН ӨРИЙГ БАРАГДУУЛАХ ЖАГСААЛТ

№	Хүлээн авах байгууллагын нэр	Нийт дүн / төгрөгөөр/
1.	Жаргалант сумын Ерөнхий боловсролын 12 жилийн Прогресс сургууль	11200000.00
2.	Жаргалант сумын Ерөнхий боловсролын 12 жилийн 6 дугаар сургууль	10150934.33
Нийт дүн		21350934.33

-oOo-